



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Жижиг дунд
Үйлдвэрлэлийг дэмжих төвийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,357,750.00 (хоёр сая гурван зуун тавин долоон мянга долоон зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассугай.

2.Тус хавсралтад заасан данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 2,357,750.00 (хоёр сая гурван зуун тавин долоон мянга долоон зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Налайх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв (А.Тайванбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

1150500027

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн
А/..... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилт-ний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	Лед самбар	8	ш	1	858,000.0	858,000.0	858,000.0	-	Эвдэрсэн	Устгах			
2	Утасны аппарат	13	ш	1	35,750.0	35,750.0	35,750.0	-	Эвдэрсэн	Устгах			
3	Зөөврийн компьютер	8	ш	1	1,389,000.0	1,389,000.0	1,389,000.0	-	Эвдэрсэн	Устгах			
Тоног төхөөрөмжийн дүн						2,282,750.0	2,282,750.0	-	-	-	-	-	
4	Сургалтын сандал	13	ш	3	25,000.0	75,000.0	75,000.0	-	Эвдэрсэн	Устгах	-		
Тавилга, эд хогшлын дүн						75,000.0	75,000.0	-			-		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						2,357,750.0	2,357,750.0	-	-	-	-	-	
Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгийн дүн						2,247,000.0							
Устгах хөрөнгө						110,750.00							
Худалдан борлуулах дүн						-							
Худалдсанаас олох орлого						-							
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/						-							